

## “АЖИГЛАЛТ” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг  
25-р хороо 39Б байр 15 тоот  
Утас: 9099-4959

2024. 12. 26 № 12/24  
таний -ны -т

## МОНГОЛ УЛСЫН ЁС ЗҮЙН ХОРООНД

### Тайлан хүргүүлэх тухай

Тус компаниас танай байгууллагатай байгуулсан гэрээний дагуу “Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан”-г хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

Гүйцэтгэх захирал:



Б. Содномбалжир



“АЖИГЛАЛТ” ХХК

МОНГОЛ УЛСЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2024 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ  
2024 он

## **АГУУЛГА**

СУДАЛГААНЫ БАГ

### **БҮЛЭГ 1.**

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ

### **БҮЛЭГ 2.**

ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЧИГ ҮҮРГИЙН  
ҮНЭЛГЭЭ

2.1.Хууль тогтоомжийн хэрэгжилт, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд хийгдсэн  
ажлын талаар

2.2.Сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар

### **БҮЛЭГ 3.**

БУСАД ЧИГЛЭЛЭЭР

3.1.Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны орчин, нөхцөл

3.2.Ёс зүйн зөрчил, өргөдөл, санал гомдол, шийдвэрлэлтийн талаар

**ДҮГНЭЛТ**  
**ЗӨВЛӨМЖ**

## СУДАЛГААНЫ БАГ

Л.Энхбаяр  
Б.Алтанцэцэг  
Д.Жаргалсайхан

Багийн ахлагч, Ажиглалт  
Судалгааны зохицуулагч, Ажиглалт  
Судалгааны зохицуулагч, Ажиглалт

“Ёс зүйн хорооны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн чиг үүргийн үнэлгээний тайлан”-г тус хорооны захиалгаар “Ажиглалт” компани 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 12 дугаар сарын 26-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Тус тайланд тусгагдсан дүгнэлтүүд зөвхөн судалгааны багийн гишүүдийн байр суурийг илэрхийлж буй болно.

## БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ

### 1.1 Судалгааны зорилго, зорилт

Монгол Улсын Ёс зүйн хороо нь холбогдох хууль тогтоомж, түүний дотор Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” болон Хорооны дүрмээр хүлээсэн чиг үүрэг, тухайн жилийн зорилт, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоохоор “Байгууллагын үйл ажиллагаа буюу чиг үүргийн үнэлгээ” хийлгэсэн болно.

Хууль, дүрэм, журмаар хүлээсэн Ёс зүйн хорооны чиг үүрэг, өнөөгийн байдал, үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдал, тулгамдаж буй асуудлыг чиг үүргийн шинжилгээний арга зүйд тулгуурлан мониторинг хийж цаашдын үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмжийг өгөхөд чиглэсэн болно.

Ёс зүйн хорооны өнөөгийн гүйцэтгэж буй чиг үүргийг ангилан, шинжилснээр цаашид байгууллагыг хөгжүүлэх арга замуудыг тодорхойлж, төрийн албаны шинэтгэл, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагад эерэг өөрчлөлт авч ирэхэд дэмжклэг болох юм.

### 1.2 Судалгааны арга, арга зүй

Үнэлгээг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоол, Хууль зүйн яамнаас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, үйл ажиллагааны тайлан, тоо баримт гэх мэт мэдээллийн эх сурвалжийг судалж, баримт бичгийг нягтлах, дүн шинжилгээ хийх аргыг ашиглалаа.

Байгууллагын чиг үүргийн үнэлгээ хийхдээ богино хугацаанд баримт бичигт дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж бичих, тайлан гаргах, тус Хорооны удирдлагад танилцуулах зэрэг үе шаттай ажлуудыг гүйцэтгэсэн болно.

### 1.3 Судалгааны түүвэр ба хамрах хүрээ

Ёс зүйн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт зэрэг холбогдох баримт бичгүүд, Хорооны зарим удирдлага, албан хаагчидтай ярилцлага хийх, асуулгын хуудсаар мэдээлэл авах, тухайн үйлчилгээ үзүүлж буй газарт судлаач өөрийн биеэр очин ажиглалт хийх зэргээр судалгааны үндсэн мэдээллийг 2024 оны 12-р сарын 13-ны өдрөөс 12-р сарын 24-ны өдрийн хооронд цуглувансан болно.

Нийтдээ тус байгууллагад 4 удаа ажиглалт хийж, байгууллагын зарим албан хаагчидтай уулзаж асуумж, тодруулга, ганцаарчилсан ярилцлага хийж, мониторингийн хуудасны бүртгэл хийсэн.

Ёс зүйн хорооны үйл ажиллагааны зорилго, зорилтод Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах<sup>1</sup> гэж заасан байна.

Ёс зүйн хорооны дүрэмд тусгагдсан чиг үүргүүдийн хэрэгжилтэд бүхэлд нь үнэлгээ хийхэд цаг хугацааны болон хүний нөөц, санхүүгийн хэрэгцээ ихээр шаардагдах, мөн 2024 оны 2 дугаар сараас үйл ажиллагаа нь албан ёсоор эхэлсэн, харьцангуй шинэ байгууллага тул Хорооны албан хаагчдын ажлын тайлан, байгууллагын жилийн ажлын тайланд үндэслэн, байгууллагын чиг үүрэгт хийх үнэлгээний үндсэн хүрээг дараах арга хэмжээний үр дүн, гүйцэтгэлийн шалгур үзүүлэлтээр тогтоосон. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Ёс зүйн хорооны дүрэм, Ажлын албаны үйл ажиллагааны дүрмийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа;
2. Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр 18-ны өдрийн 27 дугаар тогтоогоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хэрэгжилтийн хүрээнд;
3. Сургалт, соён гэгээрүүлэх зарим үйл ажиллагаа зэрэг болно.

Үйл ажиллагааны дээрх чиг үүргийн хүрээнд хэсэгчлэн үнэлгээ хийж, дүгнэлт гарган, нэгдсэн зөвлөмж боловсруулснаас гадна дараах бүлгээр ангилан үнэлэлт өгсөн болно. Тухайлбал:

1. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны орчин, нөхцөл;
2. Ёс зүйн зөрчил, өргөдөл, санал гомдол, шийдвэрлэлтийн байдал.

### **Түүврийн шалгуур**

Стандартчилагдсан ярилцлагад хамрагдах үйлчлүүлэгч дараах шалгуурыг тавьсан.

- 18-аас дээш настай байх
- Судалгаа авч байх үед тухайн шатны байгууллагаас ямар нэгэн үйлчилгээ авсан болон авахаар бүртгүүлсэн байх.

### **1.4 Мэдээлэл цуглуулах арга**

#### **Судалгааны үндсэн аргууд**

<sup>1</sup> Эх сурвалж <https://ec.gov.mn/mission>

Судалгааны мэдээллийг байгууллагын төлөөлөлтэй хийх ярилцлага, баримт бичгийн судалгаа, ажиглалтын хуудас гэсэн тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан цуглуулав.

#### **Баримт бичгийн судалгаа**

Тухайн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхийн тулд салбарын хууль тогтоомжийг судлахаас гадна байгууллагын холбогдох баримт бичгүүдийг цуглуулж дүн шинжилгээ хийсэн болно.

#### **Ажиглалтын хуудас**

Судалгаа явагдсан цэг бүрт нэг ажиглалтын хуудас бөглөсөн. Ажиглалтын хуудас нь тухайн үйлчилгээний орчин нөхцөлийг үнэлэх гол хэрэглэгдэхүүн юм.

Орчин нөхцөлийг дүрсэлж болохуйц зүйлсийг ажиглалтын хуудаст оруулсан бөгөөд судлаачийн субъектив нөлөөллийг бууруулахын тулд хэрхэн үнэлсэн талаарх тэмдэглэлийг тайлбар хэсгийн асуулт тус бүрд оруулж өгсөн.

#### **Ганцаарчилсан ярилцлага**

Ганцаарчилсан ярилцлагаар тоон судалгаагаар төдийлөн илрэх боломжгүй тухайн салбартай холбоотой асуудлыг илрүүлэн гаргаж ирэхийг зорьсон. Тухайн байгууллагын албан хаагчтай хийх асуумж, ярилцлагын үед оролцогчид тухайн асуудлыг нөгөө талаас нь тодруулах, шалтгаан нөхцөлийг илүү гүнзгий тайлбарлах боломжтой байдаг.

### **1.5 Мэдээллийн дүн шинжилгээ**

**Тоон судалгааны шинжилгээ:** Ажиглалтын хуудас болон анкетын анхдагч мэдээллийг MS EXCEL программд шивж оруулсан бөгөөд энэ явцад гарах алдааг 2 хувиас хэтрүүлэхгүй зорьж ажилласан. Шивж оруулсан мэдээллийг бөглөсөн асуулгатай тулган шалгаж, мэдээлэл программд алдаагүй орсон эсэхийг нягтлаад механик болон логик алдааг шалгаж чанарын шаардлагад нийцүүлэн боловсруулалт хийллээ.

Тоон судалгааны мэдээллийн боловсруулалтад сонирхож байгаа үзүүлэлтийн дан тоололтоос гадна харьцуулсан шинжилгээний аргыг өргөнөөр ашиглов.

**Чанарын судалгааны шинжилгээ:** Ганцаарчилсан ярилцлагын мэдээллийн зарим кейс жишээг шигтгээ байдлаар давхар оруулж өгсөн нь илүү бодитой дүр зургийг харуулахад тусална.

### **1.6 Мониторингийн хязгаарлагдмал тал**

#### **Түүвэр харьцангуй байх тохиолдол:**

Ёс зүйн хороо нь хууль тогтоомжийн дагуу Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтны ёс зүйтэй холбоотой асуудлыг хянан үзэхээс гадна яам, агентлагууд, аймаг

нийслэл дэх төрийн байгууллагуудын Ёс зүйн Дэд хороодыг мэргэшил, арга зүйн нэгдсэн удирдлага, зөвлөмж, чиглэлээр ханган ажилладаг.

Иргэд, байгууллагуудаас цахимаар болон биечлэн ирүүлсэн гомдол, хүсэлтийг хүлээн авах, холбогдох байгууллагуудад шилжүүлэх, дүгнэлт гаргах, зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээ үзүүлдэг байна.

Мөн байгууллагын үйл ажиллагаа, иргэдийн сэтгэл ханамжийг судлахын тулд тухайн байгууллагын үйл ажиллагаанд гаргасан санал гомдолд баримт бичгийн судалгаа хийсэн бөгөөд тухайн хувь хүн болоод байгууллагын нууц гэсэн үүднээс зарим талаар хязгаарлагдмал нөхцөлд танилцах боломжтой байсныг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн зарим нэгэн иргэдтэй уулзахад энэ талаар дургүйцэл илэрхийлэх, болгоомжлох, эсрэгээр өөрийн хувийн баримт бичиг, холбогдох материалыг дэлгэрэнгүй үзүүлж харуулах, зураг авхуулахыг үл зөвшөөрөх, асуулт ярилцлагад төвийг сахисан байдлаар хандаж байсан.

Энэ нь энэхүү судалгааны хоёр дахь хязгаарлагдмал тал болно.

---оОо---

## **БҮЛЭГ 2. ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЧИГ ҮҮРГИЙН ҮНЭЛГЭЭ**

### **2.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Ёс зүйн хорооны дүрэм, Ажлын албаны үйл ажиллагааны дүрмийн хүрээнд:

Төрийн албаны тухай анхдагч хууль 1994 оны 12 дугаар сард батлагдсан. Улмаар 2002 онд хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.4, 10.5, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1.5, 35 дугаар зүйлийн 35.1.7 хэсэгт нэмэлт өөрчлөлт, 2017 оны шинэчилсэн найруулгаар 26 дугаар зүйлийн 26.3, 36 дугаар зүйлийн 36.1, 37 дугаар зүйлийн 37.1.7, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, 66 дугаар зүйлийн 66.1.1, 74 дүгээр зүйлийн 74.1.2 дахь хэсэгт төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг тус тус зохицуулан тусгажээ.

2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдан мөрдөгдөж эхэлсэн нь Төрийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаандаа ёс зүйн хэмжээг мөрдөх суурь хууль болсон гэж үзэж байна.

Уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 11.5 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 04 дүгээр, “Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус баталж Ёс зүйн хороо албан ёсоор бүрэн эрхээ хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдсэн.

Монгол Улсын Ёс зүйн хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих, нэгдсэн дүн төлөв байдлын тайлан гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх хараат бус, бие даасан байгууллага юм.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороо нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллана”, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Ёс зүйн хороо нь Төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна.”, 11.2 дахь хэсэгт “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хороо өөрийн бүтцийн нэгж болох Ажлын албатай байна...” гэж тус тус заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 5, орон тооны бус 4 нийт 9 гишүүн, Ажлын албаны 24 албан хаагчийн бүтэц, орон тооны хязгаартайгаар 2024 оны 02 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Ёс зүйн хороо нь 2024 онд дараах тогтоолуудыг хуралдаанаараа тус тус батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- “Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 04 дүгээр,
- “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлах тухай” 05 дугаар,
- “Ёс зүйн хорооны хуралдааны дэг батлах тухай” 07 дугаар,
- “Ажлын албаны үйл ажиллагааны дүрэм батлах тухай” 08 дугаар,
- “Ёс зүйн хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” 09 дүгээр,
- “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 10 дугаар,
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам батлах тухай” 13 дугаар,
- “Ёс зүйн хороо гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэх журам батлах тухай” 14 дүгээр,
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын агуулга, сэдэв батлах тухай” 15 дугаар тогтоолууд болно.

Ёс зүйн хороо нь 2024 онд ёс зүйн дэд хороод болон томилох эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, байгууллага салбарын бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх тухай Ёс зүйн хорооны даргын 2024 оны 26 дугаар, 1/91 дүгээр албан бичгүүдээр тус тус хүргүүлэн удирдамж, зөвлөмжөөр хангаснаас гадна 2024 оны 09 дүгээр сараас дэд хороодод зориулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаар гарын авлага боловсруулж, цахим хэлбэрээр 61 дэд хороонд хүргүүлэн ажиллажээ.

Ёс зүйн хорооноос хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд баталсан 2024 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоол, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол, “Журам батлах тухай” 13 дугаар тогтоолыг аймаг, нийслэлийн Засаг дарга наарт болон яамдын Төрийн нарийн бичгийн дарга наарт 2024 оны 09 дүгээр сарын 06-ны 4/120 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

Төрийн байгууллага, тэдгээрийн харьяа газар, төрийн болон орон нутгийн өмчit улсын үйлдвэрийн газар, төрийн бус байгууллагуудаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн талаар захиалгат сургалт хийлгэх, чиглэл авах тухай нийт 31 албан бичиг тайлант хугацаанд ирснийг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэж хамтарч ажилласан байна.

Хороо нь 2024 онд 1,159.4 сая төгрөгийн төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж Ажлын алба, цалин хэлс, нийгмийн даатгал, үндсэн үйл ажиллагааны зардал, бараа материал, тавилга, программ хангамж, тоног төхөөрөмжийн худалдан авалтад 2024 оны 12 дугаар сарын 24-ий өдрийн байдлаар 1.112 сая төгрөг зарцуулж, 94.6 хувийн гүйцэтгэлтэй, шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг тухайд нь хуулийн хугацаанд мэдээлж, санхүүгийн үйл ажиллагааны хувьд **ЗӨРЧИЛГҮЙ** ажиллажээ.

Ёс зүйн хорооноос төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль эрх зүйн орчин, Ёс зүйн хорооны чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйт төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх цахим сургалтын баазыг бий болгох, хөгжүүлэх, олон улсын шилдэг туршилагыг судлан нэвтрүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн банк, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага зэрэг олон улсын байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газрууд, зарим элчин сайд нартай ажил хэргийн уулзалт хийж, хамтын ажиллагааны чиглэлүүдээ тодорхойлсноос гадна Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс тэргүүтэй төлөөлөгчид Америкийн Нэгдсэн Улс, Канад Улсад, Төрийн албаны зөвлөлийн гишүүн болон Ёс зүйн хорооны гишүүн Б.Идэрчулуун Швейцарын Холбооны Улсад, гишүүн Б.Пүрэвдагва Бүгд Найрамдах Турк Улсад тус тус ажлын айлчлал хийж, төрийн албаны ёс зүй хариуцлагын тогтолцоог судалж, хамтын ажиллагааг хөгжүүлэх эхлэлийг тавьжээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг Улсын Их Хурлын даргын 2023 оны 209 дүгээр захирамжаар байгуулагдаж, тус ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг байгуулан ажилласан. Энэ хүрээнд УИХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын 27 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсан.

Үндэсний хөтөлбөрийн төслийг Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 2 дугаар хуралдаан, 04 дүгээр сарын 09-ний өдрийн 3 дугаар хуралдаанаараа хэлэлцэж, төслийг бүрэн эхээр нь Улсын Их Хурлын [D-Parliament](#), Ёс зүйн хорооны [www.ec.gov.mn](http://www.ec.gov.mn), Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) зэрэг албан ёсны цахим хуудас дээр байршуулж төрийн 45 байгууллагаас 489 санал, 7 удаагийн хэлэлцүүлгийн 50 оролцогчоос давхардсан тоогоор нийт 520 гаруй саналыг авч төсөлд нэгтгэн ажилласан нь ихээхэн ач холбогдолтой болж, өргөн хүрээг хамарч чадсан гэж үзэж болохоор байна.

Ёс зүйн хороо нь “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсантай холбогдуулан хэрэгжилтэд нь хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах үүргийг хариуцан ажиллах ба энэ хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн Ёс зүйн хорооны даргын 1/108 тоот албан бичгээр үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийг хууль тогтоомжид нийцүүлэн салбар, байгууллагын бодлого, төлөвлөлтэд санхүү, төсвийн эх үүсвэрийн хамт тусган хэрэгжүүлэх чиглэлийг яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мөн хүргүүлжээ.

Тус үндэсний хөтөлбөрийн 1.2.1, 4.2.3-т заасан ёс зүйн индексийн шалгуур үзүүлэлтүүд батлуулах ажлын хүрээнд Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (OECD), Европын холбоо (EU), Европын зөвлөл (EC) зэрэг олон улсын байгууллагуудаас баталсан Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд (WGI), Олон улсын төрийн албаны үр ашгийн (InCiSE) зэрэг индексийн аргачлал, мэдээллийг судлан боловсруулах ажил хийгдэж байгаа талаар тайланд дурджээ.

Мөн хөтөлбөрийн 3.3.2-т ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн бүрэлдэхүүн болгон хөгжүүлж, үйл ажиллагаандаа тогтмол ашиглана гэж заасны дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж эхэлжээ.

Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системийг 2025 оноос эхлэн улсын хэмжээнд нэвтрүүлэхээр төлөвлөсний дагуу Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн суурь бүртгэл болон хүний нөөцийн өгөгдөл тулгуурлан <https://www.hrm.csc.gov.mn> холбоосоор 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр ашиглалтад оруулж, суурь өгөгдөл бүрдүүлэх болон Засгийн газрын дэргэдэх ёс зүйн дэд хороо, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодыг бүртгэх, нарийн бичгийн дарга нарт ашиглах сургалт явуулах зэрэг бэлтгэл ажлыг эхлүүлсэн байна.

Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын систем ашиглалтад орсноор гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны үйл явц цахимжиж дүн шинжилгээ хийх, нэгдсэн тайлан мэдээ гаргах, хүнд суртал шат дамжлагыг багасгах, хөнгөн шуурхай байдлыг хангах, цахим суурь дата үүсгэх, төсөв зардал хүн хүч хэмнэх, байгууллага ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж, хяналт тавих боломжийг бий болгох, төрийн үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл бэхжих зэрэг олон эерэг сайн талтай гэж үзэж байна.

...Төрийн албан хаагчид холбогдуулан гаргаж буй гомдол мэдээллийн дийлэнх хувийг буюу 80 орчим хувийг харилцаа хандлагын зөрчил гаргасан, ажил үүргээ хангальтгүй биелүүлсэн гэсэн талаарх тоо баримт эзэлсэн байdag. Гэхдээ энэхүү гомдол мэдээллийг шалгахад яг ёс зүйн зөрчил мөн гэж үзэх үндэслэл муутай асуудлууд багагүй таардаг. Тухайн байгууллагын Ёс зүйн дэд хороогоор гомдоо тавьж хэлэлцүүлж шийдүүлэхгүйгээр манай Хороо руу гомдол хүсэлтээ шууд гаргах асуудал их байна. Ингэснээр цөөн орон тоотойгоор ажилладаг бидний ажлын ачааллыг ихээр нэмэгдүүлэх боллоо. Иймээс иргэд олон нийт, байгууллага болон төрийн албан хаагч нарт хандсан сургалт сурталчилгааны ажлыг байнга хийх шаардлагатай гэж үздэг....

**Ёс зүйн хорооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас, 2024 он**

Ёс зүйн хорооны дүрэмд Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Хорооны хуралдаан байна гэж заасан ба 2024 онд нийт 17 удаа хуралдаж 48 /63.6 цаг/ 21 асуудлыг хэлэлцэн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих, Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтныг арга зүйн удирдлагаар хангах, төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах, ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг баталж, мөрдүүлэх чиглэлээр холбогдох тогтоол, шийдвэрийг гарган хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

#### Хорооны 2024 оны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм



Ёс зүйн хорооноос ёс зүйн дэд хороо, эрх бүхий албан тушаалтны чиг үүргээ хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар нэгдмэл ойлголт өгч, арга зүйгээр хангахын зэрэгцээ төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, баримтлах зарчим, харилцаа хандлага, ёс зүйн хариуцлагын төрөл зэрэг сэдвээр Ёс зүйн хорооны дарга, гишүүдээр ахлуулсан 5 Ажлын хэсэг 2024 оны 3-5 дугаар сард 21 аймагт ажиллаж, сургалтад нийт 15,000 гаруй төрийн албан хаагчийг хамруулжээ.

Ёс зүйн хорооноос 2281 ёс зүйн дэд хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл, арга зүйн зөвлөгөө өгсний үр дүнд ёс зүйн дэд хороод өөрсдийн санал санаачилгатай ажиллаж байгааг дурдсан байна.

Ёс зүйн хорооноос ёс зүйн дэд хороодод чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил, чиглүүлэх, мэргэшил арга зүйгээр хангах хүрээнд зохион байгуулсан ажлуудыг байгуулагдсан цаг хугацаатай уялдуулан үзэхэд цөөхөн орон тоотойгоор богино хугацаанд харьцангуй өргөн хүрээг хамарч ажиллсан нь сайшаалтай байна. Гэвч 2022 оны байдлаар нийт 2281 ёс зүйн зөвлөл ажиллаж байсан нь өнөөдрийн хувьд дээр дурьдсан тоо хэвээр байх бөгөөд нэмж байгуулагдсан ёс зүйн хороо, түүнд хамаарах

төрийн албан хаагчидтай холбоотой гомдол, мэдээлэл хэрхэн шийдэгдэж байгаа нь тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

.....Манай байгууллага нь МУ-ын бүх л иргэн, хуулийн этгээдтэй харилцдаг, үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд албан хаагч нартай холбоотой хандлага харилцааны зохиисгүй байдал гаргасан гэхчлэн гомдол мэдээлэл байнга гарч байдаг, нотолгоо, үндэслэлгүй гомдол гаргасан нь ч бас цөөнгүй...

...Ёс зүйн дэд хорооны гишүүдийн хувьд гишүүн байлаа гээд нэмэлт цалин хөлсгүй, тусгайлсан төсөв байхгүй, урамшуулал тооцож олгогддог урамшууллын хувь бага, зарим тохиолдолд хүний муу үзсэн муу нэртэй ч болчихдог ажил...

**УБЕГ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүнтэй хийсэн ярилцлагаас, 2024 он**

**Дүгнэлт:** “Ёс зүйн хорооны үйл ажиллагаанд хийсэн чиг үүргийн үнэлгээ”-г Ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, бусад хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт гэсэн шалгуураар авч үзэн, 90% оноогоор үнэллээ.

## 2.2. Сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар

Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдүүлэх, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор тус Хорооноос сургалт, нөлөөллийн олон ажлыг хийж гүйцэтгэсэн талаар тайландаа дурдсан байна.

Тухайлбал, 2024 оны 07 дугаар сард Улсын Их хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо, Төрийн албаны зөвлөлтэй хамтран сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хэрэгцээ ба агуулга” сэдэвт хэлэлцүүлгийг УИХ, Засгийн газрын харьяа байгууллагууд, удирдах албан тушаалтан, ЗГХЭГ, ХЗДХЯ, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нар, тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг агентлагийн дарга нар, яамдын Ёс зүйн дэд хороодын төлөөлөл, их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачдыг оролцуулан 2 удаа зохион байгуулсан байна.

Төрийн албан хаагч нь ажил, үүргээ ёс зүйтэй гүйцэтгэх мэдлэг, чадвараа сайжруулах, ёс зүйг дээдэлсэн соёлыг бүрдүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, манлайлах мэдлэг, чадвараа дээшлүүлэх, ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг байгууллагын түвшинд удирдан зохион байгуулах онол арга зүйг эзэмших зэрэгт чиглэсэн сургалтын агуулга, сэдвийг тодорхойлж, сургалтын хөтөлбөр, гарын авлага зэргийг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахад энэхүү хэлэлцүүлэг нь онцгой ач холбогдолтой болсон байна.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын агуулга, сэдэв”-ийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ёс зүйн хорооны 14 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, 15 дугаар тогтоолоор батлуулсан байна.

Ёс зүйн хорооноос 11 дүгээр сарыг “**ЁС-той ЗҮЙ-тэй**” нөлөөллийн аян болгон зарлаж, аяны хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебнари цахим сургалтын платформоор “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд”, “Төрийн албан хаагчийн ёс зүй (гомдол, мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх)”, “Дижитал ёс зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүй: Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа” гэсэн 4 үндсэн сэдвээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн талаар төрөөс баримталж буй бодлого, хэрэгжилт, анхаарах асуудлын талаар чиглэл өгч ажилласан байна.


2024 оны 2 дугаар сараас 12 дугаар сарыг хүртэлх хугацаанд ёс зүйн сэдвээр Төрийн албаны зөвлөлийн цахим сургалтын системийг ашиглан 10 удаагийн сургалтад 26200 онлайн эрхээр нийт 49400 төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан хаагч, ёс зүйн дэд хороодын гишүүдийг хамруулсан байна.

Мөн онд улсын хэмжээнд ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалт, соён гэгээрүүлэх ажилд нийт 71512 төрийн албан хаагч хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад 44467-оор их буюу 2,6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2024 онд Ёс зүйн хорооноос хийсэн Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, бусад холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг таниулах сургалтыг Төрийн албаны зөвлөлөөс 2021-2023 онд хийсэн мөн сургалттай харьцуулахад тухайн жилийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Энэ нь төрийн байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтан, албан хаагч, ажилтнуудын дунд ёс зүйн хэм хэмжээ, сургалт сурталчилгаа, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний эрэлт хэрэгцээтэй эрс нэмэгдэж байгааг харуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2021-2023 онд хийсэн сургалт ба  
Ёс зүйн хорооны 2024 оны сургалт



Ёс зүйн хорооноос 2024 оны 09 дүгээр сард байгууллагынхаа албан ёсны [www.ec.gov.mn](http://www.ec.gov.mn) цахим хуудас, “Ёс зүйн хороо” фэйсбууц хуудсыг нээн, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, цахим сургалт, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг түгээн ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг таниулах нөлөөллийн аяныг зохион байгуулах, нийгэмд ёс зүй, ёс суртахууны зерэг чиг хандлагыг бий болгох чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүд, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Батлан хамгаалах яамны холбогдох албаны хүмүүстэй уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, цаашид хамтран ажиллах санал, чиглэлийг тогтоосон байна.

Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороонд танилцуулах байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, Ёс зүйн дэд хорооны журмыг хэрэглэх талаарх зөвлөмж, Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх талаарх зөвлөмж, гарын авлагыг хэвлэн түгээсэн байна.

Ёс зүйн хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу нийт 4239 төрийн байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо байгуулах, 226496 төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлийг хянан, шийдвэрлэх чиг үүргийнхээ дагуу 2024 оны 12 дугаар сарын байдлаар 2281 ёс зүйн дэд хороонд 9855 гишүүд ажиллаж байна гэж тайландаа дурдсан байна.

....Төрийн алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшилүүлэх, ухамсарт нөлөөлөх нэгэн гол хүчин зүйл бол сургалт, сурталчилгааны ажлыг чанартай, хүртээмжтэй байлгах, төрийн албанад шинээр томилогдож буй албан хаагчдын сургалтыг тогтолцоожуулах шаардлагатай. Зөвхөн төрийн алба хаагч л ёс зүйтэй байхыг шаарддаг, ойлгодог байсан бол одоо тэр, хувийн хэвшил гэлтгүй иргэн бүр бие биеэсээ ёс зүйтэй байхыг шаарддаг болжээ. Ёс зүйтэй ухамсартай иргэн бий болох, төлөөвшихөд ч энэ мэдээж сайн нөлөөтэй.

Ёс зүйн хороонд төрийн байгууллагуудаас, ёс зүйн дэд хороодоос, тэр бүү хэл хувийн хэвшлийн газруудаас хүртэл сургалт хийлгэх хүсэлт ирдэг.

**Ёс зүйн хорооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас, 2024 он**

**Дүгнэлт:** Ёс зүйн хороо нь ёс зүйн дэд хороог эмхлэн байгуулах үүргийг хүлээгээгүй боловч Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар түүний харьяалах байгууллага, албан тушаалтанд ёс зүйн дэд хороог байгуулах, төсөв хөрөнгийг шийдвэрлэх хугацаатай үүрэг даалгавар өгөх чиглэлээр хамтран ажиллах боломжийг судлан үзэх, алхам хийх шаардлагатай гэж үзэж байна.

“Ёс зүйн хорооны үйл ажиллагаанд хийсэн чиг үүргийн үнэлгээ”-г сургалт, соён гэсээрүүлэх үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ гэсэн шалгуур үзүүлэлтийн хурээнд авч үзээд, хэрэгжилтийг 95% оноогоор үнэллээ.

## БҮЛЭГ 3.

### 3.1. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны орчин, нөхцөл

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3. дахь хэсэгт Ёс зүйн хороо нь Төрийн албаны зөвлөлийн 5 гишүүн, орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна гэж заасны дагуу Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны холбогдох тогтоолоор орон тооны бус 4 гишүүнийг томилсаноор Хороо бүрэн бүрэлдэхүүнээр үйл ажиллагаагаа эхлүүлэн анхны хуралдаанаа хийж Ёс зүйн хорооны даргыг сонгосон байна.

Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Ажлын албаны үйл ажиллагааны дүрэм”-д зааснаар тус хороонд мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлж, техник зохион байгуулалтын үйлчилгээгээр ханган ажиллах чиг үүрэгтэй Ажлын алба ажиллаж байна.

Ёс зүйн хорооны бүтцийн бүдүүвч



Ёс зүйн хорооны Ажлын албаны батлагдсан орон тоо 24 боловч одоогийн байдлаар 15 албан хаагч (тэргүүн түшмэл 1, эрхэлсэн түшмэл 3, ахлах түшмэл 5, дэс түшмэл 3, төрийн үйлчилгээний албан тушаалтан 3) ажиллаж байна.

Монгол Улсын Ёс зүйн хороо нь байгууллагаад удаагүй (10 сар) шинэ байгууллага, орон тоо дутуу хэдий ч өдийг хүртэлх хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил үүрэг, боловсруулж батлуулсан хууль тогтоомж, хөтөлбөр арга хэмжээ, сургалт нөлөөллийн ажлууд зэргийг дүгнэн харвал богино хугацаанд ачаалалтай, их зүйлийг ажил хэрэг болгон амжилттай ажилласныг онцлох нь зүйтэй.

Сул орон тоог нөхөх талаар Хорооноос ажлын зар, сэлгэн ажиллах заруудыг хэд хэдэн удаа зарлаж байсан ч тухайн сул орон тоонд ажиллах хүсэлтэй иргэд бүртгүүлээгүй, орон тоо бүрэн нөхөгдөөгүй байна.

Ажлын байрны орчин нөхцөлийн хувьд тус Хороо нь Засгийн газрын 11 дүгээр байрны 10 дугаар давхарт 1001-А, 1001-Б, 1003 тоот нийт 3 өрөөнд өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр өрөөнүүдийн м2-ын талбайн хэмжээ нь тухайлбал 1003 тоот өрөө нь 18 мкв хэмжээтэй, уг өрөөнд 4 албан хаагч, 1001-А тоот өрөө нь 32 мкв хэмжээтэй, уг өрөөнд 8 албан хаагч, 1001-Б тоот өрөө нь 18 мкв хэмжээтэй, хурлын өрөөний зориулалтаар тохижуулсан өрөөнд Ажлын албаны дарга байрлан ажиллаж байна.

Монгол Улс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны орчинд **MNS 5027:2001** стандартад заасанчлан нэг хүнд ногдох талбайн хэмжээ 6 мкв, эзлэхүүн нь 20 м кубээс багагүй байхаар заасан байдаг боловч дээрх ажлын байранд нэг хүнд ногдох талбайн норм стандарт зөрчигдэж байгааг харуулж байна.



Ёс зүйн хороогоор үйлчлүүлэхээр болон өргөдөл, гомдол, санал гаргахаар ирсэн иргэн, төрийн албан хаагчийг хүлээн авч уулзах тусгайлсан уулзалтын өрөө байхгүйн улмаас тухайн албан тушаалтантай уулзах үед ямар асуудал тавьж явааг тухайн өрөөний албан хаагч нар бүгд сонсох эсвэл ажлаа орхин түр гарцаах, нийтийн коридорын хэсэгт уулзаж ярилцах гэх мэт хүндрэлтэй байдал үүсдэг байна.

### 3.2. Ёс зүйн зөрчил, өргөдөл, санал гомдол, шийдвэрлэлтийн талаар

Ёс зүйн хороонд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой нийт 40 гомдол, мэдээлэл ирснээс 1 нь зөрчил тогтоогдож, харьяаллын дагуу 31 гомдлыг ёс зүйн дэд хороонд шилжүүлж, шийдвэрлэх шатандаа байгаа нь 10 байна.

Ажлын албаны 2024 оны сүүлийн хагас жилийн тайланд дурдсанаар Улсын хэмжээнд нийт гомдол, мэдээллийн тоо 755, үүнээс гэмт хэргийн шинжтэй 4, сахилгын шинжтэй 106, зөрчлийн шинжтэй 50, ёс зүйн зөрчилтэй холбоотой 595 тус тус бүртгэгдсэн байна. Энэхүү 595 гомдол мэдээллээр зөрчил тогтоогдсон 322, зөрчил тогтоогдоогүй 221, хянан шалгах ажиллагааны шатанд 52 байна.

Төрийн албан хаагчийн үйлдэл, үйл ажиллагаанд гаргасан ёс зүйн гомдол, мэдээллийн 47.5 хувь нь иргэнээс төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд, 40.6 хувь нь төрийн албан хаагчаас төрийн албан хаагчдаа, 11.9 хувь байгууллагын дотоод хяналт, шалгалтаар илэрсэн ёс зүйн зөрчил байна. Гомдол, мэдээлэлд холбогдогчдын 8.3 хувь нь төрийн улс төрийн, 38.3 хувь нь төрийн захиргаа, 10.0 хувь нь төрийн тусгай, 39.4 хувь нь төрийн үйлчилгээ, хуулийн 14.3.1, 14.3.2-т зааснаас бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан 4.0 хувийг эзэлж байна.

Өмнөх 5 жилийн дунджаар жилд 495 албан хаагч ёс зүйн зөрчил гаргаж байсан бол 2024 онд 600 болж өссөн нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14.3-дахь заалтын дагуу ёс зүйн зөрчил гаргасан төрийн улс төр, төрийн тусгай ангилал болон хуульд заасан бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтныг нэмж бүртгэдэг болсонтой холбоотой гэж үзсэн байна.

Ёс зүйн зөрчил нь тогтоогдож, хуулийн дагуу дүгнэлт нь гарсан 314 төрийн албан хаагчийн 259 албан хаагч нь “томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр”, 55 албан хаагч нь “ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээсэн” байна. Нийт 595 ёс зүйн гомдол, мэдээллийг хянаж үзэхэд зөрчил тогтоогдоогүй 221, зөрчил тогтоогдсон 322, хянаж байгаа 52 байна. Үүнээс 259 буюу 82.5 хувьд томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хариуцлага хүлээлгэсэн, 55 буюу 17.5 хувь нь сайн дураараа ёс зүйн хариуцлага хүлээсэн байна.

Мөн ёс зүйн хариуцлага хүлээсэн албан хаагчдыг албан тушаалын төрлөөр авч үзэхэд удирдах 24 (7.6%), гүйцэтгэх 241 (76.8%), туслах 49 (15.6%) байна. Гүйцэтгэх албан хаагч удирдах болон туслах албан хаагчаас 3.3 дахин их байгаа тул сургалт, нэлөөллийн арга хэмжээг уг бүлэгт чиглүүлэх хэрэгтэй болохыг харуулж байна.

Томилох эрх бүхий албан тушаалтан Ёс зүйн хороо болон Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйл болон 17 дугаар зүйлд заасны дагуу “гомдол гаргагчид, эсхүл хамт олон, олон нийтийн өмнө училалт гуйхыг үүрэг болгох” 82, “өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах” 84, “байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах” 80, “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах” 13, ёс зүйн хариуцлагаа сайн дураараа хүлээн зөвшөөрч “хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө училалт гуйх” 42, “өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх чөлөөлөгдөх хүсэлт гаргасан” 13 албан хаагчид, нийт 314 төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн байна.

Тус хорооноос нэвтрүүлэхээр боловсруулж байгаа Ёс зүйн бүртгэл, хяналтын цахим систем нь улсын хэмжээний ёс зүйн зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авах, түүний шийдвэрлэлтийг бүртгэх, хяналтын цахим сан бүрдүүлэх, үйл ажиллагааг тайлагнах, олон нийтэд мэдээлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, гомдол мэдээллийн нэгдсэн тайлан гаргах, шийдвэрлэлтэд хяналт тавих, холбогдох талуудыг мэдээллээр хангах, дүн шинжилгээг хийх боломжтой болно. Ингээнээр аль шатанд ямар зөрчил ихээр гарч байгааг илрүүлэн дүгнэлт хийж тухайн зорилтот бүлэгт чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг авч ажиллах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлийг судалж, зөрчлийн өнөөгийн төлөв байдлыг жил тутам тодорхойлох судалгааны үндэслэл, арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулах чиглэлээр судлаачидтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хамтран ажилласан талаар тайланда мөн дурдсан байна.

Энэ хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт болон энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, онол, арга зүй, олон улсын туршлагыг тоймлон судлах, Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоож, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох асуудлаар талуудын төлөөллийг оролцуулсан бүлгийн ярилцлага зохион байгуулах, үр дүнг нэгтгэн боловсруулах судалгааны арга зүй, асуулга удирдамжийг боловсруулсан байна.

## ДҮГНЭЛТ

Ёс зүйн хорооны 2024 оны үйл ажиллагааг дараах байдлаар дүгнэлээ. Үүнд:

1. Ёс зүйн хороо нь тайлант онд Улсын Их Хурлаас баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" зэрэг бодлогын баримт, бичгүүдийн үзэл баримтлал, холбогдох зүйл, заалтыг удирдлага болгон, хэрэгжилтийг ханган ажилласан байна,
2. Төрийн албаны тухай болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль түүнийг дагалдан гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлан таниулах, бусад хууль тогтоомжоор хүлээсэн үргийг биелүүлсэн байна. Хууль тогтоомжийн нийцлийг хангах, мэргэжлийн ёс зүйн асуудлыг (шүүгч, прокурор, эмч, багш ...гэх мэт) тодорхой болгох шаардлагатай.
3. Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах хүрээнд, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу стратеги төлөвлөгөөг боловсруулан анхны хэлэлцүүлэг хийж батлахад бэлэн болгосон,
4. Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Ёс зүйн дэд хороодын ажиллах журам"-ыг боловсруулан баталж, төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодод хүргэж, мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах үүргээ хэрэгжүүлсэн байна. Ийнхүү мэргэжил арга зүйгээр хангахын зэрэгцээ шаардлага хүргүүлж, биелэлтийг эргэн мэдээлэх, дэд хороодын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шийдвэр гаргах асуудлыг тодорхой болгох шаардлагатай нь харагдаж байна.
5. Төрийн бүх шатны ангиллын байгууллагын ёс зүйн байдалд дун шинжилгээ хийж, төлөв байдлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох судалгааны бэлтгэлийг хангаж, судалгааг эхлүүлсэн,
6. Ёс зүйн зөрчилтэй холбоотой бүртгэл, мэдээ мэдээллийн ил тод байдлыг хангах, тайлан мэдээг шуурхай, чигрэгдэлгүй хүлээн авч боловсруулахад чиглүүлэн Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим системийг туршилтаар эхлүүлж, улсын хэмжээнд нэвтрүүлэхэд бэлэн болгосон,
7. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Үндэсний хөтөлбөрт заасан ёс зүйн сургалтын агуулга, сэдвийг боловсруулан Төрийн байгууллагуудын сургалт судалгааны байгууллага, холбогдох албан тушаалтан, дэд хороодоор хэлэлцүүлж, баталсан,

8. Ёс зүйн хорооны гишүүдийн хариуцах асуудал, хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн нийт асуудал зэргийг нягтлан үзвэл ажлын ачаалал, цаг хугацааг зарцуулсан байгаа нь үндсэн орон тоогоор ажиллах шаардлагатайг харуулж байна,
9. Ёс зүйн хорооны бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд эрх зүй, санхүү төсөв, ажлын байрны асуудлыг шийдвэрлэх,
10. Албан хаагчдын ажлын ачаалал болон нэг хүнд ногдох өрөө тасалгааны талбайн стандарт хэмжээг баримтлах, дутуу орон тоог нэн даруй нөхөх, үндсэн орон тоог нэмэгдүүлэх.

2024 оны үйл ажиллагааны тайланг үндэслэн дараах 2 үндсэн чиг үүргийн хүрээнд дүнг гаргасан болно. Үүнд:

Д/д	Чиг үүрэг	Үнэлгээ
	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, Ёс зүйн хорооны дүрмийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны талаар	
1	Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр 18-ны өдрийн 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хүрээнд	90%
2	Сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар	95%
	<b>Ерөнхий дүн</b>	<b>92.5%</b>

Ёс зүйн хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох баримт бичгийн судалгааны үндсэн дээр үнэлгээ хийж, Ерөнхий дүнгээр **92.5%** буюу “Маш сайн” гэж дүгнэж байна.

-оOo-

## **ЗӨВЛӨМЖ**

Ёс зүйн хорооны үйл ажиллагаанд чиг үүргийн үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, эерэг хандлага, ойлголт, ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд хөрөнгө зарцуулж, идэвхжүүлэх;
2. Төрийн албананд анх томилогдож буй болон албан тушаал дэвшин томилогдож буй албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага, манлайлал, байгууллагын соёлыг бүрдүүлэх талаарх ойлголт мэдлэгийг орчин үеийн арга хэрэгслийг ашиглан олгоход дэд хороодтой хамтран ажиллах;
3. Ёс зүйн төлөв байдалд хөндлөнгийн хяналт, үнэлгээг хийж хэвшүүлэхэд төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын оролцоог хангах;
4. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдах шаардлагатай нийт 4239 /одоогоор байгуулагдсан 2281/ Ёс зүйн дэд хороо болон төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлийг хянан, шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлэх, мэргэшил арга зүйн зөвлөгөөр хангах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй;
5. Иргэдийг хүлээн авч уулзах, гомдол, санал хүсэлтийг сонсох тусгайлсан өрөөг бий болгох;
6. Албан хаагчдын сул орон тоо /8/-г нөхөж ажлын ачааллыг тэнцвэржүүлэх;
7. Албан хаагчдын ажиллах өрөө тасалгааны нэг хүнд ногдох талбайн стандартыг хангаж ажиллах.

---оОо---